

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дүгээр
сарын 29-ний өдрийн 04 дүгээр
тогтоолын 9 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНД
САНАЛ БОЛГОСОН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС
ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН**

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид “журам” гэх/-ын 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.6-д заасны дагуу Ажлын хэсэг нь олонхын саналаараа Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд санал болгосон нэр дэвшигчийн талаарх тайланг энэхүү загварт нийцүүлэн бичих үүрэгтэй.

1	Эцэг/эхийн нэр: Ганзориг Ургийн овог: Буурлууд Нэр: Эрдэнэбулган Хүйс: Эрэгтэй Төрсөн он: 1986 Төрсөн газар: Улаанбаатар хот, 2-р төрөх эмнэлэг Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэгт оршин суудаг.
Сонгон шалгаруулалт, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга Сонгон шалгаруулалтын есөн үе шат тус бүрийг журмын Дөрөв, Тав, Зургаа, Долоо, Найм, Ес, Арав, Арван нэг, Арван хоёр, Арван гуравт заасны дагуу хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой, ойлгомжтой бичнэ.	
2	Нэгдүгээр үе шат <i>Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг Монгол Улсын Их Хурлаас нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулж томилохоор заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл нэр дэвших тухай хүсэлт, баримт бичгийг хүлээн авах тухай зарыг Монгол Улсын Их Хурлын цахим хуудас, Монгол үндэсний олон нийтийн радио телевиз, хэвлэл мэдээллийн сайт болон өдөр тутмын хоёроос доошгүй өдрийн сонинд нийтлүүлж нийтэд мэдээлсэн.</i>
3	Хоёрдугаар үе шат <i>Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож, хүсэлт, баримт бичгийг 21 хоногийн хугацаанд хүлээн авахаар нийтэд мэдээлсэн бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Г.Эрдэнэбулган нь хүсэлт, холбогдох баримт бичгээ хугацаанд нь буюу 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ирүүлснийг Байнгын хорооны ажлын алба хүлээн авсан.</i>
4	Гуравдугаар үе шат <i>Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална.” гэж заасан.</i> <i>Дээрх заалтын дагуу Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын</i>

	гишүүн Д.Ганбат ахалж, гишүүдэд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга Ч.Сарангэрэл, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Д.Батмөнх, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Я.Жавхлан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн З.Сүхбаатар, Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн Б.Баасандорж, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, профессор Б.Амарсанаа, “Шихихутуг” их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн захирал, доктор, профессор Б.Нармандах, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн багш С.Сүхчулуун нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.
5	Дөрөвдүгээр үе шат Ажлын хэсэг 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль болон Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д заасан баримт бичгийн шаардлагыг хангасан гэж үзэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 12 иргэнийг нэр дэвшигчээр бүртгэсэн бөгөөд 2 иргэнийг хуульд заасан “эрх зүйчээр 10-аас доошгүй жил ажилсан байх” гэсэн шаардлага нотлогдоогүй гэж үзэн бүртгэхээс татгалзсан болно. Ажлын хэсгийн энэхүү хуралдаанаар хүсэлт, баримт бичгээ ирүүлсэн Г.Эрдэнэбулганг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэсэн.
6	Тавдугаар үе шат “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 9.1-д “нэр дэвшигчээр бүртгэснээс хойш ажлын нэг өдрийн дотор нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, нийтэд түгээнэ.” гэж заасны дагуу дээр дурдсан 12 нэр дэвшигчийн баримт бичгийг www.parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан. Г.Эрдэнэбулганы нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн нээлттэй байршуулсан.
7	Зургадугаар үе шат Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 10.1-д “Энэ журмын 9.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг нэр дэвшигчийг Ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж илтгэгч гишүүнийг томилно” гэж заасныг баримтлан 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар нэр дэвшигч тус бүрийн илтгэгч гишүүнийг сугалаагаар тодруулж, илтгэгч гишүүнийг томилсон. Нэр дэвшигч Г.Эрдэнэбулганы илтгэгч гишүүнээр Ажлын хэсгийн гишүүн Д.Сүнжид, Б.Баасандорж нар сонгогдсон бөгөөд илтгэгч гишүүн Журмын 10.4-т заасан ажиллагааг явуулж холбогдох мэдээллийг цуглуулсан.
8	Долдугаар үе шат Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 11.1-д “Энэ журмын 10.10-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигчийн талаар бүрдүүлсэн мэдээллийг нягтлах, тодруулах зорилгоор Ажлын хэсэг хэлэлцүүлэг зохион байгуулна.” гэж, 11.2-д “Ажлын хэсэг зургаагаас доошгүй тооны гишүүний

	<i>ирцтэйгээр хэлэлцүүлгийг хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч даргална.” гэж заасан.</i> <i>Ажлын хэсгийн гишүүд 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Төрийн ордны “Үндсэн хууль танхимд” нэр дэвшигч Г.Эрдэнэбулгантай ажлын хэсгийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</i>
9	Наймдугаар үе шат <i>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 12.1-д “Энэ журмын 11.6-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.” гэж, мөн журмын 13.2-т “Ажлын хэсэг энэ журмын 13.1-д заасан нэр дэвшигчийн нэр, тэдгээрийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.” гэж заасны дагуу саналаа Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх зохицуулалттай.</i> <i>Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4.5-т “Энэ хуулийн 77.4.4-т заасан санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэл хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.” гэж заасан. Ажлын хэсэг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, илтгэгч гишүүн бүр өөрсдийн судалсан нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулж, ажлын хэсгийн бусад гишүүн саналаа хэлж, асуулт асууж хэлэлцсэн. Үүний дараагаар санал хураалтыг нууцаар явуулахад нэр дэвшигч Г.Эрдэнэбулганыг Ажлын хэсгийн 8 гишүүн дэмжиж, олонхын санал авсан тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэрийг нь дэвшүүлэхээр шийдвэрлэсэн.</i>
10	Есдүгээр үе шат <i>Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшигч Г.Эрдэнэбулганыг Хууль зүйн байнгын хороонд санал болгохоор тогтож, Ажлын хэсгийн тогтоол баталсан болно.</i>
11	Сонгон шалгаруулалтын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгарууларх” журамд заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж, сонгон шалгаруулалтыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулж явуулсан болно.</i>
Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан тухай үнэлгээ Нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, нэр дэвшигчийн хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээлэл, олон нийтээс ирүүлсэн асуулт, санал, нэр дэвшигчийн талаар бусад хүмүүстэй хийсэн ярилцлага, нэр дэвшигчтэй илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн хэлэлцүүлэг, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, нэр дэвшигчээс болон бусад этгээдээс гаргуулан авах зэргээр цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтад тулгуурлан нэр дэвшигчид тавих шаардлагыг яагаад хамгийн сайн хангасан гэж үнэлж дүгнэсэн тухайгаа журмын 12.6.3-т заасны дагуу ойлгомжтой, тодорхой бичнэ.	
12	Хууль зүйн өндөр мэргэшилтэй: хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай тухай Нэр дэвшигчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай байх шалгуурыг хангаж байна гэж үзсэн. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар хууль зүйн яамыг ерөнхий чиг үүргийн яам байхаар эрэмбэлэн хуульчилсан бөгөөд хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь эрх зүйн шинэтгэлийн бодлого; хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааны асуудлыг эрхлэхээр хуульчилсан байна.

Нэр дэвшигч Г.Эрдэнэбулган нь дээрх асуудлыг хариуцсан албан тушаалтнаар сүүлийн 3 жил ажилласан нь хууль тогтоомж боловсруулах, эрх зүйн системчлэлийн чиглэлээр нарийн мэргэшсэн байна.

Түүний хууль боловсруулах, эрх зүйн бодлого тодорхойлохтой холбоотой дараах ур чадварыг хууль зүйн өндөр мэргэшилтэй гэх шалгуурт хамруулан авч үзэв. Үүнд:

Нэг. Хууль зүй, дотоод хэргийн яам - Хууль зүйн бодлогын газрын даргаар ажилласан туршлага.

1/ Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах ажилд оролцсон.

2/ *“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” /2024-2030/-г батлуулах ажилд оролцсон.*

3/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийг боловсруулах ажилд оролцсон.

4/ Хүний эрхийг хангах чиглэлээр багц хуулийн төслийг боловсруулж оролцсон байна. Үүнд:

- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /11 хулийн төсөл/.

5/ Шүүн таслах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажилд оролцсон байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024.04.05-ны өдрийн А/97 дугаар тушаалаар шүүн таслах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах, шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэх болон шүүхийн цахимжилтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Ажлын хэсгээс дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулахад оролцсон байна. Үүнд:

- Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

6/ Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах ажилд оролцсон.

7/ Хууль зүй, дотоод хэргийн салбарт Жендэрийн бодлого, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах бодлогыг боловсруулж, батлуулсан байна. Тус яамны Сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн газраас хариуцан Хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл ажиллагаанд баримтлах Жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги /2026-2029/, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах стратеги /2026-2029/-ийг тус тус боловсруулах, батлуулах ажилд оролцсон.

Хоёр. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар-Засгийн газрын референтээр

ажилласан туршлага.

Нэр дэвшигч хууль зүйн ур чадвараа тодорхойлохдоо 2015-2022 онд Монгол Улсын гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газрын ажлын алба буюу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газарт Засгийн газрын референтээр ажилласан хугацааны үүрэг хариуцлагаа дурдсан байна. Тус хугацаанд Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэлийн удирдлага болон бусад төрийн байгууллагатай харилцах асуудал, түүнчлэн бүхий л салбарын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах ажил үүрэг хашиж, бодлого боловсруулах чиглэлээр мэргэшин ажилласан болохоо дурдсан байна. Тухайлбал, энэ хүрээнд 30 гаруй хуулийн төсөл, 700 гаруй тогтоол, шийдвэрийн төслийг бие даан боловсруулах ажлыг хариуцан гүйцэтгэснээс онцолбол, Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах болон “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай” НҮБ-ын конвенц, Дэлхийн шуудан холбооны байгууллагын дүрэм, конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг боловсруулах Ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажиллаж, хуулийн төслүүд 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр тус тус батлагдсан нь харилцаа холбооны салбарын эрх зүйн орчинг сайжруулах ажилд томоохон дэвшил болсныг дурдсан байна.

Мөн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга, гишүүнээр 2017 оноос эхлэн тус тус ажиллан, улмаар дагалдах 17 хууль тогтоомжийн төслийн хамт эцэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан болно. Энэхүү хууль нь 1994 онд батлагдсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийслэлийн хэмжээнд үүсч тулгамдсан маш олон асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг өөртөө агуулснаар чухал ач холбогдолтой болсон. Түүнчлэн, Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д бусад хуулийг нийцүүлэх, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажиллаж, улмаар салбар бүрийн өөрчлөлт оруулах шаардлагатай нийт 127 хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан эдгээр хуулиуд нь Үндсэн хуулийн хүрээнд орон нутгийн бие даасан байдлыг хангахад томоохон шинэчлэлийн ажил болсон байна.

Гурав. Барилга, хот байгуулалтын яам- Хуулийн хэлтсийн даргаар ажилласан туршлага.

Салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Газрын багц хуулийн төсөл, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2016 онд батлагдсан), Хот байгуулалтын тухай, Авто зогсоолын тухай, Хот, тосгоны ногоон байгууламжийн тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай (2015 онд батлагдсан) зэрэг Монгол Улсын барилга, хот, байгуулалт болон газрын харилцааны салбарын суурь эрх зүйн орчныг сайжруулах, шинээр бий болгох чиглэлээр холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байсан байна.

Дөрөв. Хувийн хэвшилд ажиллах хугацаанд хөдөлмөр, компанийн болон иргэний эрх зүйгээр дагнан мэргэшсэн бөгөөд гадаад худалдааны гэрээ хэлцлүүд дээр ажиллаж байсан туршлага.

Тухайлбал, Таван богд группээс олон улсын франчайз эрхийн хүрээнд хэрэгжүүлсэн KFC түргэн хоолны сүлжээ рестораны гэрээ хэлцэл болон тус

	компанийн Дархан-Уул аймагт шинээр хэрэгжүүлсэн гурилын үйлдвэрийн төслийн хүрээнд гадаад улсын хуулийн этгээдтэй байгуулах гэрээ хэлцлүүдийг хариуцан боловсруулж ажиллаж байсан байна. Эдгээр туршлага нь эрх зүйч мэргэжлээр төрийн болон хувийн хэвшилд ажилласан туршлага үүнээс чиглэлийн яам болох хууль зүйн яамны хууль зүйн бодлогыг хариуцсан албан хаагчаар ажиллаж байсан нь нэр дэвшигчийн хууль зүйн өндөр мэргэшлийг хангалттай харуулж байна гэж дүгнэж байна.
13	Хууль зүйн өндөр мэргэшилтэй: мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан тухай Нэр дэвшигчийн төлөвшил, хандлага, хамтран ажиллагсад, урьд өмнө удирдан ажиллаж байсан удирдах албан тушаалтан, одоо түүний удирдлагад ажиллаж буй албан тушаалтнуудын ярилцлагын явцад цугларсан баримтуудад түшиглэн буюу үндэслэн тус нэр дэвшигч нь бусдын нөлөөнд автахгүйгээр хараат бусаар ажиллах, цаашлаад ялгаатай байр суурт дээр бусдын ялгаатай үзэл бодлыг хүндэтгэн зарчимч, шударга зан төлөвөөр хандаж чадах бөгөөд мэргэжлийн ёс зүйн шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.
14	Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан тухай Эрх зүйч мэргэжлээрээ ажиллаж туршлага хуримтлуулсан туршлагын хувьд мэргэжлээрээ тасралтгүй нийт 17 жил ажилласан байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөс үндэслэн дараах байдлаар ажилласан гэж үзэв. <u>Үүнд:</u> (i) 2009.06-2010.06 сарыг хүртэл “Нью прогресс групп” ХХК-ийн Захирлын ажлын албанд Хуулийн мэргэжилтэн (ii) 2010.06-2013.05 хүртэл “Таван богд трейд” ХХК-ийн Хууль, эрх зүйн албанд Хуулийн мэргэжилтэн, Хуулийн зөвлөх (iii) 2013.05-2015.01 сарыг хүртэл Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газарт Хуулийн хэлтсийн дарга (iv) 2015.05-2022.01 сарыг хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газарт Засгийн газрын референт (v) 2022.06-2023.10 сарыг хүртэл “Ханхөгшин интернэшнл” ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал (i) 2023.10-2024.11 сарыг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга; (ii) 2024.11-2025.11 сарыг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн газрын дарга; (iii) 2025.11-2026.04 сарыг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга 2026.04 сараас одоог хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга.
15	Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй тухай <i>Г.Эрдэнэбулган нь 1986 онд төрсөн. Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй.</i>
16	Шүүгчээр ажиллаж байгаагүй тухай <i>Нэр дэвшигчийн ирүүлсэн ТАХ-ийн анкет, НДШ төлөлтийн лавлагаанаас нэр дэвшигч сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй.</i>
17	Сүүлийн таван жилд улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй тухай <i>Г.Эрдэнэбулган нь улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй. Нэр дэвшигчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт болон хавсралтаар ирүүлсэн бусад мэдээлэлээр нотлогдсон.</i>
18	Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай

	<i>Г.Эрдэнэбулган нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй нь иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх болон байгаа эсэх талаарх лавлагаа, тодорхойлолтоор нотлогдож байна.</i>
19	Монгол Улсын иргэн мөн тухай <i>Г.Эрдэнэбулган нь Монгол Улсын иргэн мөн. Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхний лавлагаанд үндэслэв.</i>
20	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд санал болгох үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэх нь <i>Нэр дэвшигч Г.Эрдэнэбулган нь ШтХ-ийн 76 дугаар зүйлийн 76.3-т заасан ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнд тавигдах шаардлага болох хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байх шаардлагыг бүрэн хангаж байх тул нэр дэвшигч Г.Эрдэнэбулган нь холбогдох хууль, журамд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд тавигдах шаардлагыг хангаж байна гэж ажлын хэсэг үзсэн болно.</i>

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон
шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг**